



БАГА БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ 2

БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн, зөвлөмж..... 5

Хоёр. Даалгавар боловсруулах арга зүй, зөвлөмж16

Гурав. Даалгаварт шинжилгээ хийх аргачлал24

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүй


Зөвлөмжийн энэхүү хэсэгт хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсруулсан арга зүй, сургалтын үйл ажиллагаанд үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга, аргачлал, зөвлөмжийг Дүрслэх урлаг, технологийн 3 дугаар ангийн агуулга, бүлэг сэдвийн жишээгээр тайлбарлав.

✓ Үнэлгээний шалгуур боловсруулсан арга зүй

Бага боловсролын Дүрслэх урлаг, технологи хичээлийн үнэлгээний шалгуурыг дараах аргачлалын дагуу боловсруулсан.

- Дүрслэх урлаг, технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн зорилтыг задлан шинжлэх, уялдаа холбоог тогтоох
- Агуулгын уялдаа холбоог харгалзан үнэлгээний нэгжийг төлөвлөх
- Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүнг тодорхойлох
- Суралцахуйн үр дүнгээс суралцахуйн үр дүнгийн шалгуурыг боловсруулах
- Үнэлгээний шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлох

Зураг 1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур боловсруулах аргачлал



Дүрслэх урлаг, технологийн агуулга, суралцахуйн зорилтын өргөн хүрээний, хамгийн чухал мэдлэг, чадварыг харгалзан “Үнэлгээний нэгж”-ийг, нэгж агуулгын “Суралцахуйн үр дүн”-г тодорхойлсон болно.

✓ Үнэлгээний нэгж

Үнэлгээний нэгж гэдгийг тухайн ангийн агуулга, суралцахуйн зорилтын харилцан уялдаа холбоог харгалзан бүлэглэсэн агуулгын нэгж гэж ойлгож болно.

Дүрслэх урлаг, технологийн хичээлийн үнэлгээний нэгжийг сургалтын хөтөлбөрийн агуулгын тогтолцоо, анги хоорондын залгамж холбоог харгалзан төлөвлөсөн. Сургалтын хөтөлбөрийн агуулга үнэлгээний нэгжийг хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Үнэлгээний нэгж (3 дугаар ангийн агуулгын жишээн дээр)

Сургалтын хөтөлбөрийн агуулга /бүлэг/	Үнэлгээний нэгж
1. Дүрслэх урлаг	а. Дүрслэх урлагийн хэл
	б. Урлан бүтээхүй
2. Технологи	в. Соёлын үнэт зүйл
	г. Хоёр ба гурван хэмжээст бүтээл

Үнэлгээний нэгжид хамаарах агуулгын хүрээг дараах байдлаар тодорхойлсон.

(а) “Дүрслэх урлагийн хэл”-ийн тухайд дүрслэх урлагийн бүтээлийг бүтээж буй зохиомжийн хэрэгслүүдийг танин мэдэх, онцлог шинжийг мэдэрч туршилтын бүтээл хийх, дүрслэлийн хэл, нэр томъёог үйл ажиллагаатай холбон ойлгох

(б) “Урлан бүтээхүй”-н тухайд сурагчид дүрслэлийн арга, хэрэгслээр дамжуулан бодит байдлаас хүртэж зурж, дүрслэх өөрийн сэтгэгдлээ зурах, дүрслэх, бүтээх үйлээр илэрхийлэх

(в) “Соёлын үнэт зүйл”-ийн тухайд өөрийн орны болон бусад улс орнуудын дүрслэх урлагийн зарим бүтээлээс сонгож, уран бүтээлчдийг таньж мэдэх, дүрслэх урлагийн бүтээлээр дамжуулан урлагийн үнэ цэнэ, амьдрал дахь дүрслэх урлагийн холбоо хамаарлыг ухаарч ойлгох

(г) Хоёр ба гурван хэмжээст бүтээл-ийн тухайд сурагчид хоёр ба гурван хэмжээст бүтээлийг зохиох, хийхдээ, бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал, багаж хэрэгсэл сонгох, зохиомжийн хэрэгсэл, зарчим, зохиомжийн ойлголтоо илэрхийлэх

✓ **Суралцахуйн үр дүн**

Суралцахуйн үр дүн гэдэг нь тухайн нэгжийн агуулгын судалсны эцэст хүрэх үр дүн юм.

Суралцахуйн үр дүнг анги тус бүрийн үнэлгээний нэгжид хамаарах агуулгын хамгийн чухал мэдлэг, эзэмших чадварыг багтаан тодорхойлсон. Хүснэгт 2-оор харуулав.


Хүснэгт 2. Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал (VI анги)

№	Сургалын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Нэгжийн суралцахуйн үр дүн
1	3.1е. Хүүхдийн зураг, бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлэх 3.1ж. Бодит болон хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тайлбарлах	Урлан бүтээхүй	ДУТ3.1 ҮД2 Сурагч уран зургийн бүтээлүүдээс гол ба туслах дүр болон орон зайн илэрхийллийг харьцуулан тодорхойлж ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлнэ.

Суралцахуйн үр дүнгийн кодын тайлбар: (ДУТ) Дүрслэх урлаг, технологийн, (3) 3 дугаар анги, (1) бүлэг/ай, (ҮД2) үр дүн 2 гэж ойлгоно.

Нэгжийн суралцахуйн үр дүнгээс анги хоорондын болон тухайн ангийн агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрлийг тодорхой харж болно.

Зураг 2. Нэгжийн агуулгын суралцахуйн үр дүн харьцуулалт (1-3 анги)



Суралцахуйн үр дүнгийн шалгуурыг суралцахуйн үр дүн, түүний танин мэдэхүйн түвшинд нийцэхүйц, сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг илрүүлэхүйц, хэмжигдэхүйц, ямар мэдлэг, чадвар, арга барилыг үнэлэхийг, анги боловсролын түвшнээр залгамж холбоотой уялдсан байхаар тодорхойлсон.

✓ **Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

Нэгж агуулгын суралцахуйн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлсон.

Хүснэгт 3. Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүн, шалгуур (3 дугаар анги 2 нэгж)

Үнэлгээний нэгж 2: Урлан бүтээхүй

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
2	ДУТ3.1 ҮД2. Сурагч уран зургийн бүтээлүүдээс гол ба туслах дүр болон орон зайн илэрхийллийг харьцуулан тодорхойлж ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлнэ.	<p>ДУТ3.1.ҮД2.Ш5. Хүүхдийн зураг бүтээлээс гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.</p> <p>ДУТ3.1.ҮД2.Ш6. Бодит болон хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ дүрсэлдэг.</p>

Суралцахуйн үр дүнгийн шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлсон ба 1-2 дугаар ангийн суралцахуйн үр дүнгийн шалгуур тус бүр гүйцэтгэлийн 3 түвшинтэй бол 3-5 дугаар ангийн суралцахуйн үр дүнгийн шалгуур нь гүйцэтгэлийн 4 түвшинтэй. Гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлохдоо танин мэдэхүйн түвшинг харгалзан үзсэн.

- I түвшин Юмс үзэгдлийн гадаад шинж чанараар нэг элементийг таних, нэрлэх, ялгаж байгаа байдал
- II түвшин Юмс үзэгдлийн элементүүдийн уялдаа холбоог ойлгосон байдлыг тайлбарлах, зураг дүрслэлээр илэрхийлж буй байдал
- III түвшин Юмс үзэгдлийг хооронд жишин харьцуулах, задлан шинжлэх үйлийн илэрхийлэл, яаж ямар аргаар хийж эсэх
- IV түвшин Шинэ санаа, арга эрж хайх, асуудлыг шийдвэрлэх, шинэ зүйл бүтээх, нэгтгэх, солих, өөрчлөх, загварчилж буй байдал

Хүснэгт 4. Суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин (3 дугаар анги 1 нэгж)

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ3.1 ҮД2 Ш5. Хүүхдийн зураг бүтээлээс гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.	Хүүхдийн зураг, бүтээлийн дүр, дүрслэлийг тоочин нэрлэдэг.	Хүүхдийн зураг, бүтээлээс гол ба туслах дүрийг нэрлэдэг.	Хүүхдийн зураг, бүтээлийн гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлдог.	Хүүхдийн зураг, бүтээлээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.

1-5 ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүнгийн шалгуурын тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. I-V ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүнгийн шалгуурын тоо


Агуулгын бүлэг/ай	Үнэлгээний нэгж	I анги	II анги	III анги	IV анги	V анги
		Суралцахуйн үр дүнгийн шалгуур (тоо)				
Дүрслэх урлаг	Дүрслэх урлагийн хэл	6	4	4	3	3
	Урлан бүтээхүй	2	2	2	3	4
	Соёлын үнэт зүйл	-	2	2	2	5
Технологи	2 ба 3 хэмжээст бүтээл	5	8	8	7	5
	Ажил мэргэжил, амьдрах ухаан	-	-	-	2	3
Нийт		13	16	16	17	20

✓ **Суралцахуйн үр дүнг үнэлэх арга зүй**

✓ **Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ**


Дүрслэх урлаг, технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний холбоо хамаарлыг дараах матриц (зураг 3)-аар харуулав.

Зураг 3. Дүрслэх урлаг, технологийн хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний матриц



Дүрслэх урлаг, технологийн хичээлээр сурагчид “Бүтээлч эрэлхийллийн арга барил”-ыг эзэмших ёстой. Энэ арга барилыг сурагчид 1) Мэдрэх, хүлээн авах 2) Бүтээх гүйцэтгэх 3) Ойлгох/ үнэлэх үе шат бүхий үйл ажиллагааны явцад эзэмшинэ.


Зураг 4. Бүтээлч эрэлхийллийн арга барил (БЭАБ), сурагчдын эзэмших чадвар



✓ Үнэлгээний арга зүй

Суралцахуйн үр дүн, сурагчдын эзэмших мэдлэг чадварыг үнэлэх арга зүйг бүдүүвчээр үзүүлье.

Зураг 5. Үнэлгээний арга зүй



✓ Үнэлгээ түүний төрөл, хэлбэр:

Үнэлгээний талаарх ойлголтыг олон янзаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, “...аливаа зүйлийн мөн чанар, үнэ цэнийг тодорхойлох үйл явц” (OECD), “Үнэлгээ нь хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг хянуур, системтэйгээр эргэж харах хандлага” (SIDA), “...чанарын тухай мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, тайлагнах үе шатуудыг агуулсан цаашдын бодлого, хэрэгжилтийг тодорхойлох систем бүхий эрэл хайгуул” (World Bank) гэж тодорхойлсон байдаг бол манай боловсролын салбарын үнэлгээний бодлогын баримт бичгүүдэд “Сурагчдын сурах үйл ажиллагааг мэдээлэх, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явц”-ыг үнэлгээ хэмээнэ гэсэн ойлголтод санал нийлж хэрэгжүүлж байна.

Сургалтын үйл ажиллагаанд үнэлгээг дараах байдлаар авч үзэж байна.

1. Оношлох үнэлгээ (diagnostic assessment)
2. Явцын үнэлгээ (formative assessment)
3. Үр дүнгийн үнэлгээ (summative assessment)

Оношлох үнэлгээ гэдэг нь хичээлийн жилийн эхэнд эсвэл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тандах зорилготой үйл явц бол явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл сургалтын явцад тогтмол хийх үнэлгээг хэлдэг байна. Харин үр дүнгийн үнэлгээ нь тодорхой хугацаанд суралцагчийн олж авсан мэдлэг, чадварын түвшнийг хэмжихэд чиглэдэг байна. Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний ялгааг түлхүүр асуултаар тодруулбал:

Үнэлгээний төрөл	Түлхүүр асуулт
1. Оношлох үнэлгээ	Сурагчид юу хэрэгтэй байна вэ?
2. Явцын үнэлгээ	Сурагчид хэр сайн суралцаж байна вэ?
3. Үр дүнгийн үнэлгээ	Сурагчид хэр сайн сурсан бэ? Ямар түвшинд хүрсэн бэ?


Үнэлгээг янз бүрийн хэлбэрээр зохион байгуулдаг. Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээ хийх түгээмэл хэлбэрүүдийн авч үзье.

Оношлох үнэлгээ	Явцын үнэлгээ	Үр дүнгийн үнэлгээ
Тест/ сорилго Судалгаа Ярилцлага Хэлэлцүүлэг Асуулт, харцулт	Ажиглалт Асуулт, харцулт Ярилцлага Хэлэлцүүлэг Асуулга Рубрик Өөрийн болон найз нөхдийн үнэлгээ	Бүлэг сэдвийн шалгалт Улирлын шалгалт Стандартчилагдсан тест Судалгааны ажил Төсөлт ажил

✓ Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээнд үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүй

Дүрслэх урлаг, технологийн үнэлгээний нэгж агуулгын гараа, явц, үр дүнг тухайн нэгжийн суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуураар үнэлнэ. Нэгж агуулгын суралцахуйн үр дүн, шалгуурыг үнэлгээнд хэрэглэх аргачлалыг зураглалаар харуулав.

Зураг 6. Нэгж агуулгын үнэлгээний зураглал



А/. Оношлох үнэлгээ: Сурагчид юу мэддэг, чаддаг, юу мэдэхгүй, чадахгүй, ямар ойлголт, төсөөлөл, хандлагатай байна вэ? гэдгийг илрүүлэх зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдэв эхлэхийн өмнө оношлох үнэлгээ хийдэг. Оношлох үнэлгээ хийснээр тухайн анги, сурагчийн ялгаатай байдлыг харгалзан агуулгыг бататгах арга зүйг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх суурь мэдээлэлтэй болно. Оношилгоо нь явцын ба үр дүнгийн үнэлгээнээс ялгаатай бөгөөд янз бүрийн хэлбэрээр хийж болно. Тухайлбал, тест/ сорилго, судалгаа, ярилцлага, хэлэлцүүлэг гэх мэт. Оношлох үнэлгээг ямар ч хэлбэрээр зохион байгуулахад оношилгоо хийх агуулга, үнэлгээний шалгуур үзүүлэлт тун чухал байдаг. Үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшинд тохирох сорилыг цогц байдлаар боловсруулж сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж болно. Аргачлалыг 3 дугаар ангийн агуулгын жишээгээр харуулав.

Жишээ 1.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.1 ҮД2. Ш5. Хүүхдийн зураг бүтээлээс гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.

- I түвшин: Хүүхдийн зураг, бүтээлийн дүр, дүрслэлийг тоочин нэрлэдэг.
- II түвшин: Хүүхдийн зураг, бүтээлийн гол ба туслах дүрийг ялгаж нэрлэдэг
- III түвшин: Хүүхдийн зураг, бүтээлийн гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлдог.
- IV түвшин: Хүүхдийн зураг, бүтээлээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.

Даалгавар 1. “Өнхрүүш” сэдэвт зургийг ажиглаарай. Даалгаврыг дараах алхмаар гүйцэтгээрэй.



Маша, нас 9. “Өнхөрүүш”

Алхам 1. “Өнхрүүш” зурагт юу юу дүрслэгдсэн байна вэ? Тоочин нэрлээрэй.

Өнхрүүш, нар, үүл, байшин, мод, цэцэг (1 оноо)

Алхам 2. Зургийн гол, ба туслах дүрийг ялгаж нэрлээрэй.

Гол дүр: _____

Туслах дүр: _____ (2 оноо)

Алхам 3. Зургийн хавтгайгаас гол ба туслах дүрийг олж тодорхойлж зургийн хавтгайд хэрхэн байрлуулж зурсныг тайлбарлаарай. (3 оноо)

Алхам 4. “Өнхрүүш” сэдэвт зургаас төрсөн сэтгэгдэл, гол ба туслах дүрийн ойлголтоо илэрхийлж сэдэвт зураг зураарай. (4 оноо)

Б/. Явцын үнэлгээ: Явцын үнэлгээ нь сурах үйл ажиллагааг танин мэдэх, суралцахууд дэмжлэг үзүүлж, сурлагын ахиц амжилтад эерэгээр нөлөөлдөг. Явцын үнэлгээг хичээл, сургалтын явцад хэрэгжүүлэх ба багшлахуй, суралцахуйн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байна. Явцын үнэлгээг маш сайн зохион байгуулснаар эцсийн үнэлгээний үр дүнг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой.

Юуг, яаж үнэлэх вэ?

Хүснэгт 6. Явцын үнэлгээ

Юуг үнэлэх вэ?	Яаж үнэлэх вэ?
Сурагчийн ахиц дэвшил	Танин мэдэхүйн түвшинд тохирсон даалгавар боловсруулж хянах ¹
Сурагчийн ташаа ойлголт	Ажиглалт, даалгаврын гүйцэтгэлээр илрүүлж залруулах
Сурагчийн хоцрогдож байгаа шалтгаан	Хоцрогдож буй шалтгааныг ажиглалт, даалгавраар тодруулах
Сурагчийн амжилт	Урамшуулах

Суралцахуйн үйл ажиллагааны явцад суралцахуйн үр дүнгийн шалгуурт тохирох үнэлгээний рубрик боловсруулж сурагчдыг үнэлж болно.

Жишээ 2. Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.1 ҮД5. Ш4. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээдэг.

Хүснэгт 7. Рубрикийн загвар

	Шалгуур	Үлгэр жишээ	Боломжийн байна	Бодох хэрэгтэй
		1 оноо	3 оноо	5 оноо
I	Цаасыг 1 нугалж хайчлан тэгш хэмт дүрс үүсгэж тайлбарлаж чадсан.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
II	Бүтээлийн онцлогт нийцүүлэн цаасыг сонгож давхарлан нугалж чадсан.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
III	Нугалж бэлтгэсэн цаасан дээр олон дүрс үүсгэх аргаар тохирох дүрсийг зурж чадсан.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
IV	Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар хийж чадсан.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

¹ Явцын үнэлгээгээр сурагчийн ахиц дэвшлийг хянаж амжилтад хүрэхэд чиглүүлнэ.

Багш үнэлгээний үр дүнд анализ хийж, тэд чухам аль шалгуур дээр хангалтгүй байгааг илрүүлж, цаашид анхаарч арга зүй, төлөвлөлтдөө тусгаж ажиллах хэрэгтэй.

Бага насны хүүхэд өөрөө сонгосон зүйлдээ илүү их анхаарал хандуулдаг. Тэдэнд хийж чадна эсвэл хийхийг хүсэх бодол төрөхүйцээр даалгаврыг сонголттой өгөх нь илүү тохиромжтой. Янз бүрийн түвшний чадвартай сурагчдад зориулж багш сургалтандаа ялгаатай түвшний даалгавар боловсруулан ашигласнаар тэдэнд тодорхой хэмжээгээр мэдлэг, чадвараа ахиулан хөгжүүлэх боломж олгоно. Ялгаатай түвшний даалгавар нь сурагчдад тодорхой хэмжээгээр “амжилт” гаргаж буйг нь мэдрүүлэн, цаашид өөрийн мэдлэг, чадвартаа бага ч гэсэн хэмжээгээр ахиц гаргаж өөрийгөө хөгжүүлэх идэвх сонирхол төрүүлэх юм. Ялгаатай түвшний даалгаврыг ээлжит хичээлд хэрэглэж болно.

✓ Суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшингээр ялгаатай түвшний даалгавар боловсруулж сурагчдын сурлагын ахиц амжилтыг үнэлж болно.

Ялгаатай даалгаврууд агуулга, бүтцийн хувьд ялгаатай байж болно. Багшийн боловсруулсан ялгаатай түвшний даалгавраас суралцагч өөрөө сонгоно. Сонгосон түвшний даалгавраа биелүүлж чадсан тохиолдолд суралцагч өөрийгөө сорьж, дараагийн ахисан түвшний даалгаврыг сонгон гүйцэтгэж явцын үнэлгээгээ ахиулах боломжтой.

Суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшингээр ялгаатай түвшний даалгавар боловсруулах аргачлалыг жишээгээр авч үзье.

Жишээ 3.

Хүснэгт 8. Суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин (2 дугаар анги)

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ2.1 ҮД1 Ш1. Үндсэн болон үүсмэл өнгийг ялган таних, үндсэн өнгөөс үүсэл өнгө үүсгэн зурж дүрсэлдэг.	Үндсэн болон үүсмэл өнгийг ялган таньж нэрлэдэг.	Үндсэн өнгийг хооронд хольж үүсмэл өнгө үүсгэдэг.	Сэдвийн хүрээнд үндсэн болон үүсмэл өнгөөр зурж дүрсэлдэг.

I түвшний даалгавар: Үндсэн болон үүсмэл өнгийг ялган нэрлээрэй.

Үндсэн өнгө	Үүсмэл өнгө


II түвшний даалгавар: Үндсэн өнгөнөөс үүсмэл өнгө гаргах туршилт хийж ажлын хуудаст тэмдэглээрэй. Хэрэглэгдэхүүн: Усан будаг болон гуашь, нэг удаа хэрэглэх аяга.

Үүсмэл ягаан өнгө	Үүсмэл ногоон өнгө	Үүсмэл улбар шар өнгө


Туршилтын үр дүнг тэмдэглэх ажлын хуудас:

- Туршилтын үр дүнг үндсэн ба үүсмэл өнгөөр хүрдний тохирох хэсэгт будаж тэмдэглээрэй.
- Үндсэн ба үүсмэл өнгийг тохирох хүснэгтэд ялган будна.

Үндсэн өнгө			
Үүсмэл өнгө			



III түвшний даалгавар: Өөрийн бодол төсөөллөөр зураг зурж үндсэн болон үүсмэл өнгөөр сонгож будаарай. Жич: Зөвхөн үндсэн 3 өнгө ашиглаж зурна.



- ✓ Ялгаатай түвшний даалгаврын гүйцэтгэлд дараах маягаар анализ хийж, сурагчдын ахиц болон ойлгоогүй зүйлийг тогтоож, түүнийг хэрхэн залруулах талаар сурагчдад зөвлөгөө өгч ажиллах боломжтой.

Хүснэгт 9. Ялгаатай түвшний даалгаврын гүйцэтгэлийг тэмдэглэх, шинжилгээ хийх загвар

Түвшин \ Сурагчийн нэр	I түвшний даалгавар	II түвшний даалгавар	III түвшний даалгавар	Зөвлөгөө өгөх (чиглэл) тэмдэглэл
Оюун		+	+	
Батаа	+	+	-	

Сурагч сайн суралцахад тухайн агуулгыг сонирхох, өөрөө хийж туршиж үзэх нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Сонирхолтой байх тусам сурагчдын анхаарал их төвлөрдөг байна. Ээлжит хичээлээр сурагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд дараах “Орох, гарах тасалбар”-ын арга ихээхэн ач холбогдолтой байдаг. Энэ арга нь сурагч өөрийгөө үнэлэх, багшид явцын үнэлгээ хийх боломжийг бүрдүүлдэг онцлогтой.

ОРОХ ТАСАЛБАР

Багш өнөөдрийн хичээлээр хийж сурах зүйлийг бичнэ.

ГАРАХ ТАСАЛБАР


Өнөөдрийн хичээлээр хийж сурсан зүйлийг бичих эсвэл хийсэн бүтээлээ найзууддаа үзүүлнэ.

Багш гарах тасалбар дээр тамгалах, янз бүрийн үнэлгээний дүрсээр үнэлэх зэргээр уг аргыг улам баяжуулж болно.


Зураг 5. Үнэлгээ хийх дүрс




Маш сайн



Сайн



Дунд зэрэг



Хангалтгүй

В/. Үр дүнгийн үнэлгээ: Нэгж агуулга, бүлэг сэдвийн төгсгөлд үр дүнгийн үнэлгээ хийнэ. Нэгж агуулгын хүрэх үр дүн, үнэлгээний шалгуурт тулгуурласан цогц даалгаврыг боловсруулж сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж болно. Зөвлөмжийн дараагийн бүлэгт даалгавар боловсруулах уг арга, аргачлалыг тусгасан болно. Дүрслэх урлаг, технологийн хичээлийн үнэлгээ нь сурагчдын бүтээлийн гүйцэтгэлд тулгуурлан үнэлэх онцлогтой. Суралцахуйн үр дүн, үнэлгээний дараах шалгуурт тохирох сэдвийн шалгатын даалгавар боловсруулж, гүйцэтгэлийн түвшингээр үнэлэх аргачлалыг 3 дугаар ангийн агуулгын жишээгээр тайлбарлав.


Суралцахуйн үр дүн: ДУТ3.2 ҮД6. Сурагч баримлын шавраар юмсын загвар хийж зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.2 ҮД6 Ш15. Баримлын шавраар юмсын загвар хийж зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээдэг.

Даалгвар: “Гэрийн тэжээмэл амьтад” сэдвээр үйл явдал илэрхийлсэн баримал бүтээгээрэй.

Сурагчдын бүтээлийг суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшингээр рубрик боловсруулж үнэлж болно.

Сурагчдын бүтээлийг үнэлэх аргачлал



Хүснэгт 10. Бүтээлийн үнэлгээний рубрикийн хувилбар

Гүйцэтгэлийн түвшин	Үлгэр жишээ	Чадварлаг	Боломж байна	Бодох хэрэгтэй
	1	3	5	7
Баримлаар үйл явдал илэрхийлсэн бүтээл хийх сэдвээ сонгон тайлбарласан байдал	Бүтээлийн сэдэв, дүрийн талаар санаагаа бүрэн илэрхийлж тайлбарласан бол	Бүтээлийн сэдэв, дүрийн талаар санаагаа илэрхийлэхдээ бага алдаа гаргасан бол	Бүтээлийн сэдвийн талаар хангалттай тайлбарлаж чадаагүй бол	Бүтээлийн сэдвийн талаар тайлбарлаж чадаагүй бол


Сэдвийн дагуу юмсын загварын бүрдэл хэсгийг баримлаар бүтээсэн байдал	Дүр, юмсын загварын бүрдэл хэсгүүдийн хэлбэрийг маш сайн илэрхийлсэн бол	Дүр, юмсын загварын бүрдэл хэсэг хэлбэрийн хувьд багахан алдаа гарсан бол	Дүр, юмсын загварын бүрдэл хэсгийн хэлбэрийг бүрэн илэрхийлж чадаагүй бол	Дүр, юмсын загварын бүрдэл хэсгийн хэлбэршүүлж чадаагүй бол
Баримлаар хийсэн бүрдэл хэсгийг холбох аргаар загварыг бүтээсэн байдал	Сэдвийн дагуу дүрүүдийг маш сайн бүтээсэн бол	Сэдвийн дагуу дүрүүдийг бүтээхдээ багахан алдаа гарсан бол	Сэдвийн дагуу дүрүүдийг бүтээхдээ дүрийн илэрхийлийг гаргаж чадаагүй бол	Сэдвийн дагуу дүрүүдийг бүтээж чадаагүй бол
Юмсын загварыг зохиомжлон байрлуулж үйл явдал илэрхийлсэн баримал бүтээсэн байдал	Дүр, юмсын загварыг сэдвийн дагуу маш сайн зохиомжлон байршуулсан бол	Дүр, юмсын загварыг сэдвийн дагуу зохиомжлон байршуулахдаа алдаа гарсан бол	Дүр, юмсын загварыг сэдвийн дагуу зохиомжил өрж чадаагүй бол	Дүр, юмсын загвар, үйл явдал илэрхийлсэн баримал хийж чадаагүй бол

Багшийн зөвлөмж: Сурагчдын агуулгаар эзэмших мэдлэг, чадвараас гадна бүтээлч эрэлхийллийн арга барил (чадвар)-ыг орхигдуулахгүйгээр хөгжүүлэхэд хичээлийн төлөвлөлт, үнэлгээний арга, аргачлал ихээхэн ач холбогдолтой. Бүтээлч эрэлхийллийн арга барилын үе шатыг хичээлийн арга зүйд тусгаж хэрэгжүүлэх замаар бүтээлчээр эрэлхийлэх чадварыг дэмжих шаардлагатай. (БЭАБ болон үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшний хамаарлыг зураг 2-аас хараарай.)

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар боловсруулах арга зүй

✓ Даалгавар боловсруулах арга зүй, зөвлөмж

Зураг 5. Даалгавар боловсруулах аргачлал



✓ Блюпринт

Блюпринт нь даалгавар боловсруулах нарийвчилсан зураглал (матриц) юм. Өөрөөр хэлбэл, даалгаврын агуулга, дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан төлөвлөлт гэж ойлгож болно. Сурагчдаас тодорхой хугацаанд тодорхой агуулгыг багтаасан сэдвийн үр дүнг илрүүлэх шалгалтын даалгавар зохиоход блюпринтийг боловсруулна. Блюпринтийг боловсруулахад таксономийн мэдлэг шаардлагатай. Одоогоор Блумын таксономи (1956), Соло таксономи (1982)-ийг боловсролын зорилт, үнэлгээг тодорхойлоход түгээмэл хэрэглэж байгаа ба энэ талаарх судалгааны үр дүн багагүй байдаг. Иймээс багш нар таксономийн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх шаардлагатай юм. Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүнг илрүүлэх шалгалтын агуулга боловсруулахдаа дараах блюпринтийн загварыг ашиглаж болох юм.

Хүснэгт 11. Блюпринт боловсруулах загвар

№	Үнэлгээний зорилт		Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин	Даалгавар		Танин мэдэхүйн түвшин			
	Мэдлэг ойлголт	Чадвар			Сонгох	Задгай	Сэргээн санах, ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	Үнэлэх, бүтээх
1										

✓ Даалгавар

Үнэлгээний зорилго, зорилтоос хамаарч даалгаврын төрөл хэлбэр харилцан адилгүй байдаг. Тэгэхдээ сонгох болон задгай даалгаврыг төрлийг даалгавар боловсруулахад түгээмэл хэрэглэдэг.

Сонгох даалгавар гэж хариултын хувилбаруудтай түүнээс зөв хариултыг сонгох хэлбэрээр боловсруулсан даалгаврыг хэлнэ. Хариултын хувилбар нь гурваас багагүй таваас ихгүй байх зохимжтой. Хариултын хувилбараас зөв хариулт зөвхөн нэг байна. Харин хариултын бусад хувилбар шалгуулагчид үнэмшил төрөхүйц байх хэдий ч, зайлшгүй буруу хариулт байна.

Задгай даалгавар нь танин мэдэхүйн дээд түвшний ур чадварыг үнэлэхэд чиглэсэн нээлттэй дэлгэрэнгүй хариултыг шаарддаг байна. Задгай хэлбэрийн даалгавар нь алхамчилсан бүтэцтэй байх бөгөөд хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн алхам бүр өөр өөр мэдлэг, чадварыг илрүүлэхээр боловсруулагдсан байхаас гадна алхмууд нь хоорондоо хамааралтай цогц даалгавар байж болно. Цогц даалгавар нь дангаараа нэг бүлэг сэдвийн агуулгыг үнэлэхээс гадна хэд хэдэн агуулгын хүрээг хамарсан байхаар боловсруулагдсан байж болно. Задгай даалгаврыг боловсруулахад даалгаврын зорилго, шалгуур нь тодорхой байх ёстой. Задгай даалгаврыг нөхөх, богино буюу товч хариулттай, дэлгэрэнгүй хариулттай гэсэн 3 төрөлд хуваадаг байна. Задгай даалгаврыг дүгнэхэд сурагчдын гүйцэтгэсэн үйлдэл бүрт оноо өгөх зарчимд тулгуурласан үнэлгээний шалгуур, оноожуулалт зайлшгүй шаардлагатай.

✓ Даалгаврын хариултын хувилбар боловсруулах аргачлал

Сонгох болон задгай даалгаврыг дүгнэхэд сурагчдын гүйцэтгэсэн үйлдэл бүрт оноо өгөх зарчимд тулгуурласан хариултын хувилбар, оноожуулалт зайлшгүй шаардлагатай. Ялангуяа задгай хэлбэрийн даалгаврын алхам бүрийн хариултын хувилбарыг урьдчилан боловсруулсан байх шаардлагатай. Энэ нь сурагчдын ялгаатай байдлыг илрүүлэх, өөрөөр хэлбэл, сурагчдын тухайн агуулга эзэмшсэн хувийг тодорхойлох боломжийг олгодог. Хариултын хувилбарыг дараах загвараар боловруулна.

Хүснэгт 12. Хариултын хувилбар боловсруулах загвар

Даалгаврын дугаар	Хариултын хувилбар		Тайлбар	Код	Оноо
	1				
	2				
	3				
	4	Дээрхээс бусад			
	5	Огт хариулаагүй			

Даалгавар боловсруулсан арга зүйг 3 дугаар ангийн дараах нэгж агуулгын жишээн дээр авч үзье.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ХОЁР БА ГУРВАН ХЭМЖЭЭС БҮТЭЭЛ**ТЕХНОЛОГИ III АНГИ**

Суралцахуйн үр дүн: ДУТ3.2 ҮД5. Сурагч цаасыг нугалах, хуйлж хэлбэршүүлэх болон үлгэр ашиглах зурж, хайчилж угсрах аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур:

- ДУТ3.2 ҮД4.Ш3. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж 3 хэмжээст загвар бүтээдэг.
- ДУТ3.2 ҮД4.Ш4. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээдэг.
- ДУТ3.2 ҮД4.Ш5. Хатуу цаасыг хуйлж хэлбэршүүлэх аргаар амьтны 3 хэмжээст загвар бүтээдэг.
- ДУТ3.2 ҮД4.Ш6. Үлгэр ашиглан эд ангийг зурж хайчилж угсрах аргаар техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.

✓ **Боловсруулсан бюпринтийн загвар**

Нэгж агуулгын суралцахуйн үр дүнгийн шалгуурт нийцсэн даалгаврын бюпринт боловсруулсан загварыг авч үзье.

Хүснэгт 13. Бюпринтийн загвар

№	Үнэлгээний зорилт		Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин	Даалгавар		Танин мэдэхүйн түвшин			
	Мэдлэг ойлголт	Чадвар			Сонгох	Задгай	Сэргээн санах, ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	Үнэлэх, бүтээх
1	40%	60%	ДУТ3.2 ҮД4.Ш3. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж 3 хэмжээст загвар бүтээдэг.	I	1		1			
				II		1		1		
				III		1		1		
				IV		1			1	
2	40%	60%	ДУТ3.2 ҮД4.Ш4. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээдэг.	I	1		1			
				II		1		1		
				III		1		1		
				IV		1			1	
3	40%	60%	ДУТ3.2 ҮД4.Ш5. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны 3 хэмжээст загвар бүтээдэг.	I	1		1			
				II		1		1		
				III		1		1		
				IV		1			1	
4	40%	60%	ДУТ3.2 ҮД4.Ш6. Үлгэр ашиглан эд ангийг зурж хайчилж угсрах аргаар техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.	I	1		1			
				II		1		1		
				III		1		1		
				IV		1			1	






✓ **Бюпринтийн дагуу боловсруулсан даалгавар**

Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.2 ҮД4.Ш3. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж 3 хэмжээст загвар бүтээдэг.


Гүйцэтгэлийн түвшин:

- I түвшин: Зааврын дагуу 5-аас дээш нугалж бүтээх зурган зааврыг уншиж тайлбарладаг.
- II түвшин: 1-2 нугалааг зааврын дагуу гүйцэтгэдэг.
- III түвшин: 3-4 нугалааг зааврын дагуу гүйцэтгэдэг.
- IV түвшин: 5-аас дээш нугалааг зааврын дагуу гүйцэтгэж 3 хэмжээст загвар бүтээдэг.


Даалгавар 1. Дараах заавар, зургийг зөв харгалзуулаарай. (1 оноо)

1		А/. Цаасыг тасархай зураасын дагуу гадагш нугалах
2		Б/. Цаасыг үргэлжилсэн зураасын дагуу хайчлах
3		В/. Ашиглах багаж, хэрэглэгдэхүүн
4		Г/. Цаасыг цэгтэй тасархай зураасын дагуу дотогш нугалах
5		Д/. Сумын чиглэлийн дагуу нугалах


Даалгавар 2. Ам дөрвөлжин цаасыг дарааллын дагуу нугалж, нохойны нүд, ам хамрыг баяжуулан зураарай.



Даалгавар 3. Ам дөрвөлжин цаасыг дарааллын дагуу нугалж, хонхон цэцэгний иш, навчийг баяжуулан зураарай.



Даалгавар 4. Тэгш өнцөгт цаасыг дарааллын дагуу нугалж завь бүтээгээрэй.




Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.2 ҮД4.Ш4. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээдэг.


Гүйцэтгэлийн түвшин:

- I түвшин: Цаасыг 1 нугалж хайчлан тэгш хэмт дүрс үүсгэж тайлбарладаг.
- II түвшин: Бүтээлийн онцлогт нийцүүлэн цаасыг сонгож давхарлан нугалж бэлтгэдэг.
- III түвшин: Нугалж бэлтгэсэн цаасан дээр олон дүрс үүсгэх аргаар тохирох дүрсийг зурдаг.
- IV түвшин: Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар хийдэг.

Даалгавар 1. Цаасыг босоо чиглэлд голоор нь нугалахад туулай дэгдээхий хоёрын аль нь тэгш хэмтэй байна вэ? Ялгааг тайлбарлаарай.




Даалгавар 2. Ам дөрвөлжин цаасыг дотогш ба гадагш нугалах тэмдэглэгээний дагуу нугалж бэлтгээрэй.




Даалгавар 3.

Давхарлаж нугалсан цаасан дээр алимны аль (бүтэн ба тал) дүрсийг зурж хайчилбал олон дүрс үүсэх вэ?



Даалгавар 4.

Нугалж бэлтгэсэн цаасан дээрээ дараах дүрсүүдээс сонгон чимэглэлийн загвар хийгээрэй.



Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.2 ҮД4.Ш5. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны 3 хэмжээст загвар бүтээдэг.


Гүйцэтгэлийн түвшин:

- I түвшин: Завсартаа зөөлөвчтэй хайрцгийн зөөлөн картоныг хуулж, зөөлөвчийг туузлан хайчилдаг.
- II түвшин: Зөөлөвчтэй туузан картоныг хуйлж хэлбэржүүлэн янз бүрийн амьтны хэлбэр үүсгэж туршдаг.
- III түвшин: Цаасаа хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны бүрдэл хэсгүүдийг бэлтгэдэг.
- IV түвшин: Бүрдэл хэсгүүдийг нааж холбох аргаар 3 хэмжээст загвар бүтээдэг.

Даалгавар 1. Картон цаасыг туузлан хайчлах аль арга нь илүү тохиромжтой вэ? Сонгож тайлбарлаарай.



Даалгавар 2. Картоныг хуйлж дараах хэлбэрүүдийг үүсгэж туршаарай.



Даалгавар 3. Дэгдээхийн бүрдэл хэсгүүдийг бэлтгээрэй.

Их биеийг зааврын дагуу эзлэхүүнт хэлбэрт оруулаарай.

	<p>Бүрдэл хэсгүүд: Толгой Их бие Хошуу Сарвуу хөл</p>	<p>Их биеийг хэлбэржүүлэх заавар:</p>

Даалгавар 4. Төрөл бүрийн амьтны хэлбэр үүсгэж харандаагаа чимэглээрэй.


	<p>Хийх дараалал</p>
<ol style="list-style-type: none"> 1. Картон цаасыг будаж туузан хэлбэртэй хайчилж бэлтгэх 2. Амьтны бүрдэл хэсгүүдийг (толгой, чих, хүзүү, нүд) хуйлж бэлтгэх 3. Амьтны бүрдэл хэсгүүдийг нааж холбох 4. Чимэглэх 	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур: ДУТ3.2 ҮД4.Ш6. Үлгэр ашиглан эд ангийг зурж хайчилж угсрах аргаар техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.

Гүйцэтгэлийн түвшин:

- I түвшин: Үлгэр зургаас техникийн загварын эд анги, бүрдэл хэсгийг нэрлэдэг.
- II түвшин: Техникийн загварын онцлогт нийцүүлэн материалыг сонгодог.
- III түвшин: Үлгэрийн дагуу техникийн загварын эд анги бүрдэл хэсгийг зурж, хайчилж бэлтгэдэг.
- IV түвшин: Үлгэрийн дагуу эд анги бүрдэл хэсгийг зурж, хайчилж угсран техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.

Даалгавар 1. Дараах авто машины үлгэр зургаас техникийн эд анги, бүрдэл хэсгүүдийг нэрлээрэй.



Даалгавар 2. Дараах авто машины загварыг хийхэд чамд ямар материал хэрэгтэй болохыг бичээрэй.



Даалгавар 3. Дарааллын дагуу онгоцны бүрдэл хэсгийг бэлтгээрэй.

	<p>Хийх дараалал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Онгоцны бүрдэл хэсгийг нэрлэх 2. Үлгэрийн дагуу бүрдэл хэсгүүдийг зурах 3. Бүрдэл хэсгүүдийг хайчлах
--	---

Даалгавар 4. Дарааллын дагуу нисэх онгоцны загварыг бүтээгээрэй.

	<p>Хийх дараалал:</p> <ol style="list-style-type: none"> 4. Онгоцны бүрдэл хэсгийг нэрлэх 5. Үлгэрийн дагуу бүрдэл хэсгүүдийг зурах 6. Бүрдэл хэсгүүдийг хайчлах 7. Бүрдэл хэсгүүдийг өнгөөр будаж баяжуулах 8. Бүрдэл хэсгүүдийг нааж угсрах
--	--

✓ Даалгаврын хариултын хувилбар

Хүснэгт 14. Хариултын хувилбар (ДУТ3.2 ҮД4.Ш3. суралцахуйн үр дүнгийн шалгуурын жишээн дээр)

Даалгаврын №	Хариултын төрөл	Хариултын тайлбар	Оноо
ДУТ3.2 ҮД4.Ш3. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж 3 хэмжээст загвар бүтээдэг. Жишээ			
1	Цаас нугалж бэлтгэдэг зааврыг таньж буй байдал -Цаас нугалж бэлтгэх зурган зааврыг зөв харгалзуулсан бол	5 зурган тэмдэглэгээний тайлбарыг зөв харгалзуулсан бол (1 оноо)	1 оноо
2	1-2 нугалааг зааврын дагуу гүйцэтгэсэн байдал Ам дөрвөлжин цаасыг дарааллын дагуу нугалж, нохойны нүд ам хамрыг баяжуулан зурсан бол	- Ам дөрвөлжин цаасыг гурвалжилж нугалсан бол (0.5 оноо) - Гурвалжингийн голыг олж чихийг зааврын дагуу хэлбэр гарган нугалсан бол (0.5 оноо) - Нүүрний хэсгийг баяжуулан зурсан бол (1 оноо)	2 оноо

3	3-4 нугалааг зааврын дагуу гүйцэтгэсэн байдал Ам дөрвөлжин цаасыг дарааллын дагуу нугалж, хонхон цэцгийн иш, навчийг баяжуулан зурсан бол	<ul style="list-style-type: none"> - Ам дөрвөлжин цаасыг гурвалжилж нугалсан бол (0.5 оноо) - Гурвалжинг тэгш хэмтэй нугалж голыг олсон бол (0.5 оноо) - Голын нугалааг ашиглан нэг дэлбээг зааврын дагуу нугалсан бол (0.5 оноо) - Голын нугалааг ашиглан үлдсэн дэлбээг ирмэг чацуулан нугалсан бол (0.5 оноо) - Иш навчаар баяжуулан зурсан бол 	2 оноо
4	5-аас дээш нугалааг зааврын дагуу гүйцэтгэж 3 хэмжээст загвар бүтээсэн бол Тэгш өнцөгт цаасыг дарааллын дагуу нугалж 3 хэмжээст бүтээл хийсэн бол	<ul style="list-style-type: none"> - Тэгш өнцөгт цаасыг нугалах тэмдэглэгээний дагуу зөв нугалсан бол (1 оноо) - Сумны чиглэлээр зааврын дагуу зөв нугалсан бол (1оноо) - Сумны чиглэл зааврын дагуу хэлбэржүүлэн завины хэлбэрийг гаргасан бол (1 оноо) 	3 оноо

Гурав. Даалгаварт шинжилгээ хийх аргачлал

Сургалтын хөтөлбөрийн агуулгаар сурагчдын эзэмших мэдлэг, чадварыг үнэлэх, хэмжээсжүүлэхэд чиглэсэн шалгалтын материал, даалгаврыг боловсруулдаг. Сурагчдын мэдлэг чадварыг хэр бодитой үнэлэх нь тухайн шалгалтын материал дахь даалгаврын чанараас шууд хамаарна. Иймд даалгаврын чанарыг тогтоох, сайжруулах зорилгоор даалгаварт шинжилгээ хийдэг. Мөн сурагчдын даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийх замаар сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг тодорхойлох нь чухал юм. Иймээс даалгаврын үр дүнг нэгтгэх шаардлагатай.

✓ Даалгаврын үр дүнг нэгтгэх

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг дараах өгөгдсөн загвараар нэгтгэж болно.

Хүснэгт 15. Сурагчдын гүйцэтгэлийг нэгтгэх загвар

	Даалгавар				Авсан оноо	Гүйцэтгэл (хувиар)	Тайлбар
	1	2	3	4			
Сурагч 1							
Сурагч 2							
Сурагч 3							
Хангалттай							
Дунд							
Хангалтгүй							

Даалгаврын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг гаргах

А/. Шалгалтын агуулгад хүнд, дундаж, хөнгөн даалгаврын хувь хэмжээг тохируулахаас тухайн шалгалтын үр дүн ямар тархалтай байх нь хамаардаг. Үр дүн нь хэвийн (нормаль) тархалттай байх нь сурагчдыг бодитой үнэлэхэд ач холбогдолтой. Мөн даалгаврыг гүйцэтгэх хугацааг бодитой тогтоох чухал байдаг. Даалгаврын хүнд хөнгөний зэрэг болон ялгах чадварын талаарх ойлголт, тооцох арга аргачлалыг судалж өөрсдийн боловсруулсан даалгаврын нийцлийг туршиж сайруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сурагчдын гүйцэтгэлд тулгуурлан даалгаврын ялгах чадвар (маш сайн, сайн, дундаж, бага, сөрөг) болон хүнд хөнгөний зэргийг (хэт хөнгөн, хөнгөн, дундаж, хүнд, хэт хүнд)

тогтоох, харилцан хамаарлыг шинжлэх замаар даалгаврыг сайжруулах чиглэлийг тодорхойлно. Ингэж сайжруулсан даалгавар нь сурагчдын мэдлэг, чадварыг бодитой үнэлэх, даалгаврын сан бүрдүүлэхэд ач холбогдолтой.

Б/. Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг нэгтгэх хүснэгт дэх мэдээлэл нь тухайн агуулга, суралцахуйн үр дүнг тодорхойлох мэдээлэл, нотлох баримт юм. Өөрөөр хэлбэл, тухайн нэгж агуулгын суралцахуйн үр дүн, шалгуурыг хэр олон сурагч хангасан эсэх, хангахын төлөө хичээж буй байдал, агуулгын хэрэгжилт хэр хангагдаж буй талаарх мэдээллийг агуулна.

В/. Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс агуулгын хэрэгжилтийн талаарх чанарын мэдээллийг цуглуулж багшлахуйг сайжруулах, нотолгоонд тулгуурласан хичээлийн арга зүйн санаа боловсруулж хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

ЕБС-ийн Дүрслэх урлаг, технологи хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

С. Отгонтуяа	Боловсролын хүрээлэнгийн ЭША
Ч. Алтанчимэг	Зөвлөх багш, 20 дугаар сургуулийн багш
С. Цолмон	Зөвлөх багш, “Шинэ эхлэл” сургуулийн багш

Хөндлөнгийн шинжээч:

Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), дэд профессор
---------	--

Техникийн редактор:

Г. Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 3.5 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-майл: info@eec.mn Вэб: www.eec.mn